МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 20

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Сүхбаатар дүүргийн прокурорын газраас санаачлан төр, нийтийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг сайжруулах, прокурорын байгууллага, төрийн байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор "Прокурор-Олон нийт" нэгдсэн арга хэмжээг эхлүүлжээ.

Тус арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, хороодын Засаг дарга болон бусад төрийн байгууллагуудын удирдлагуудад танилцуулах уулзалтыг зохион байгуулж, санал солилцжээ.



Прокурор, хорооны засаг даргын ажлын алба, цагдаагийн байгууллагын хороо хариуцсан хэсгийн байцаагч нараас бүрдсэн хамтарсан баг нийтийн эрх, ашгийг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх юм.

Тодруулбал, хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлийн гаралт шалтгаан нөхцөлийг судалж, үр дүнтэй ажил зохион байгуулах, нийтийн эрх, ашгийг хамгаалах, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, иргэд олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөжээ.

“Прокурор-Олон нийт” нэгдсэн арга хэмжээ Сүхбаатарын дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ оны гуравдугаар улирал дуустал үргэлжилнэ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1088